

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/91/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № МВА-2022/91/НА-СТА-ТЧЗ
танай _____ -ны № _____ -т

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

0200200390

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,323,485.42	43,305,780.44
33	АВЛАГА	31,554,084.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,554,084.00	00.00
335	Бусад авлага	29,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	29,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,769,401.42	43,305,780.44
351	Түүхий эд материал	706,140.00	685,440.00
35130	Эм боох материал	706,140.00	685,440.00
354	Хангамжийн материал	56,063,261.42	42,620,340.44
35410	Бичиг хэргийн материал	556,600.00	811,200.00
35420	Аж ахуйн материал	30,650,560.73	14,379,670.00
35440	Түлш, шатах тослох материал	700,012.10	00.00
35460	Хүнсний материал	7,017,609.60	5,829,484.50
35470	Бусад хангамжийн материал	17,138,478.99	21,599,985.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,147,298,060.74	2,132,159,254.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,147,298,060.74	2,132,159,254.41
392	Биет хөрөнгө	2,088,112,060.74	2,073,048,254.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,997,513,129.27	1,997,513,129.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	-124,674,293.77	-187,388,775.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,600,000.00	55,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-5,600,000.00	-9,766,666.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	248,647,461.51	250,970,325.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-174,487,720.36	-170,764,636.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	163,496,916.54	161,685,875.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-95,466,737.11	-90,138,735.39
39214	Бусад үндсэн хөрөнгө	49,754,920.00	48,191,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-21,333,711.34	-27,515,457.86
39217	Ном	44,662,096.00	44,662,096.00
393	Биет бус хөрөнгө	59,186,000.00	59,111,000.00
39301	Программ хангамж	740,000.00	740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-515,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	58,886,000.00	58,886,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,235,621,546.16	2,175,465,034.85
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,235,621,546.16	2,175,465,034.85
51	Засгийн газрын хувь оролцоо	2,235,621,546.16	2,175,465,034.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	764,402,767.34	764,402,767.34
51101	Өмч: - төрийн	764,402,767.34	764,402,767.34
512	Хуримтлагдсан үр дүн	645,505,181.31	586,842,304.14
51210	Өмнөх үеийн үр дүн	645,505,181.31	646,998,815.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-60,156,511.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	825,713,597.51	824,219,963.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,235,621,546.16	2,175,465,034.85

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,292,618,710.63	1,162,211,345.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,899,710.63	67,320,106.95
120	Нийтлэг татварын бус орлого	105,133,930.63	67,320,106.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,091,930.63	67,320,106.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	105,091,930.63	67,320,106.95
120009	Бусад орлого	42,000.00	00.00
122	Тусламжийн орлого	62,765,780.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	62,765,780.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,775,000.00	195,490,439.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	976,944,000.00	899,400,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,358,000.00	8,572,339.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,358,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,008,149.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,564,190.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,417,000.00	186,918,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,417,000.00	186,918,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,210,141,346.87	1,222,232,832.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,210,141,346.87	1,222,232,832.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,116,299,539.29	1,178,889,942.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	716,886,325.34	710,577,957.29
210101	Үндсэн цалин	537,675,231.34	478,643,862.40
210102	Нэмэгдэл	118,491,932.00	163,282,605.11
210104	Урамшуулал	56,099,162.00	61,800,571.39
210105	Гэрээт ажлын хөлс	4,620,000.00	6,850,918.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,963,312.00	90,961,248.41
210201	Тэтгэврийн даатгал	61,537,759.00	63,906,958.33
210202	Тэтгэмжийн даатгал	7,242,747.00	7,155,305.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,796,598.00	5,724,244.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,398,746.00	1,376,878.24
210205	Эрүүл мэндийн даатгал	13,987,462.00	12,797,861.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,151,491.08	184,069,883.18
210301	Гэрэл, цахилгаан	5,316,616.08	7,105,623.18
210302	Түлш, халаалт	131,814,875.00	176,764,260.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,897,055.63	26,795,830.10
210401	Бичиг хэрэг	5,707,530.00	6,799,250.00

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	4,789,122.90	2,768,312.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,800.00	1,220,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,005,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,902,602.73	15,408,268.00
2105	Нормативт зардал	48,695,433.90	49,009,020.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,091,000.00	2,631,700.00
210502	Хоол, хүнс	47,604,433.90	46,377,320.10
2107	Томилолт, зочны зардал	690,800.00	886,700.00
210702	Дотоод албан томилолт	690,800.00	886,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,373,600.00	1,002,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	403,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	5,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.00	599,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,641,521.34	115,587,103.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	755,200.00	7,232,322.73
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,886,321.34	108,354,781.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,841,807.58	43,342,889.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,925,300.00	30,853,850.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,615,300.00	28,232,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,310,000.00	2,621,450.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,874,307.58	9,666,483.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,874,307.58	9,666,483.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,200.00	2,822,555.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,200.00	2,822,555.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>82,477,363.76</u>	<u>-60,021,486.08</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	135,025.23
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	25,025.23
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	110,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-135,025.23
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>82,477,363.76</u>	<u>-60,156,511.31</u>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,152,110,777.00	1,094,891,239.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	42,000.00	00.00
120009	Бусад орлого	42,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,152,068,777.00	1,094,891,239.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	976,944,000.00	899,400,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,358,000.00	8,572,339.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,358,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,008,149.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	2,564,190.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	142,417,000.00	186,918,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	142,417,000.00	186,918,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	27,349,777.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	27,349,777.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,152,110,777.00	1,094,891,239.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,152,110,777.00	1,094,891,239.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,030,919,192.42	1,051,548,349.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,455,757.34	708,023,873.29
210101	Үндсэн цалин	479,854,095.12	462,276,544.06
210102	Нэмэгдэл	169,798,872.00	181,232,515.29
210104	Урамшуулал	59,004,981.22	54,474,495.38
210105	Гэрээт ажлын хөлс	9,797,809.00	10,040,318.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,947,964.00	90,961,248.41
210201	Тэтгэврийн даатгал	62,272,310.00	63,381,884.52
210202	Тэтгэмжийн даатгал	7,326,154.00	6,980,025.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,860,923.00	5,583,939.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,383,372.00	1,365,017.21
210205	Эрүүл мэндийн даатгал	14,105,205.00	13,650,382.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	139,909,016.08	184,169,883.18
210301	Гэрэл, цахилгаан	5,316,616.08	7,105,623.18
210302	Түлш, халаалт	134,292,400.00	176,764,260.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	10,691,540.00	8,969,350.00
210401	Бичиг хэрэг	509,980.00	1,004,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,011,610.00	2,068,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,800.00	1,220,000.00
210404	Ном, хэвлэл	465,350.00	465,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,845,000.00	3,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,366,800.00	960,400.00
2105	Нормативт зардал	40,311,215.00	46,271,395.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	667,800.00	635,200.00
210502	Хоол, хүнс	39,097,415.00	45,089,195.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	546,000.00	547,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,286,800.00	4,235,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,800,000.00	1,735,000.00
210602	Тавилга	7,991,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,495,800.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	690,800.00	886,700.00
210702	Дотоод албан томилолт	690,800.00	886,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,673,600.00	1,502,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	403,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	5,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	599,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,952,500.00	6,528,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,952,500.00	6,528,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,191,584.58	43,342,889.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,275,077.00	30,853,850.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	27,349,777.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,615,300.00	28,232,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,310,000.00	2,621,450.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	79,874,307.58	9,666,483.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,874,307.58	9,666,483.30
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,200.00	2,822,555.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,200.00	2,822,555.82
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	705,516,767.34	331,134,868.92	-285,816,678.37	750,834,957.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,448,533.04	1,448,533.04
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	705,516,767.34	331,134,868.92	-284,368,145.33	752,283,490.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	58,886,000.00	00.00	851,176,845.12	910,062,845.12
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	764,402,767.34	825,713,597.51	645,505,181.31	2,235,621,546.16
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	764,402,767.34	825,713,597.51	645,505,181.31	2,235,621,546.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,493,634.14	1,493,634.14
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	764,402,767.34	825,713,597.51	646,998,815.45	2,237,115,180.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,493,634.14	00.00	-1,493,634.14
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-60,156,511.31	-60,156,511.31
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	764,402,767.34	824,219,963.37	586,842,304.14	2,175,465,034.85

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,086,318,900.00	1,076,404,199.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,318,900.00	1,076,404,199.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,054,260,500.00	1,046,860,349.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,145,100.00	708,023,873.29
210101	Үндсэн цалин	473,997,900.00	462,276,544.06
210102	Нэмэгдэл	179,614,400.00	181,232,515.29
210104	Урамшуулал	46,452,800.00	54,474,495.38
210105	Гэрээт ажлын хөлс	10,080,000.00	10,040,318.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,869,800.00	90,961,248.41
210201	Тэтгэврийн даатгал	67,463,800.00	63,381,884.52
210202	Тэтгэмжийн даатгал	7,101,500.00	6,980,025.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,681,200.00	5,583,939.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,420,300.00	1,365,017.21
210205	Эрүүл мэндийн даатгал	14,203,000.00	13,650,382.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	184,418,100.00	184,169,883.18
210301	Гэрэл, цахилгаан	7,350,000.00	7,105,623.18
210302	Түлш, халаалт	176,768,100.00	176,764,260.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,393,000.00	7,390,350.00
210401	Бичиг хэрэг	714,600.00	720,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,070,000.00	2,068,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	492,800.00	455,000.00
210404	Ном, хэвлэл	465,800.00	465,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,720,000.00	2,720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	929,800.00	960,400.00
2105	Нормативт зардал	46,311,800.00	46,271,395.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	667,800.00	635,200.00
210502	Хоол, хүнс	45,096,900.00	45,089,195.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	547,100.00	547,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	887,800.00	886,700.00
210702	Дотоод албан томилолт	887,800.00	886,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,580,200.00	1,502,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	599,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5154700.00	5154700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,154,700.00	5,154,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32058400.00	29543850.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,058,400.00	29,543,850.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,746,900.00	28,232,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,311,500.00	1,311,450.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,086,318,900.00	1,076,404,199.88
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	899,400,800.00	889,734,316.70
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	899,400,800.00	889,734,316.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	186,918,100.00	186,669,883.18
132001	Орон нутгийн төсвөөс	186,918,100.00	186,669,883.18
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61.00	61.00
620001	Удирдах ажилтан	04.00	04.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61.00	61.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	37.00	37.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	22.00
650010	Гэрээт ажилтан	02.00	02.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,998,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,998,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,688,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,579,000.00
210401	Бичиг хэрэг	284,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,735,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,735,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1374000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,374,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1310000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,310,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,310,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8572339.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,572,339.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,008,149.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,564,190.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3 . Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургууль нь бүх нийтийн ерөнхий боловсролыг суралцагчдад эзэмшүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 9,681.1 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,122,232.8 төгрөгийн 1 хувь буюу 11,122.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,977.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,156.5 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материал, авлага данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	31,554.1	0	-31,554.1
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	56,769.4	43,305.8	-13,463.6
Үндсэн хөрөнгө	2,147,298.0	2,132,159.2	-15,138.8
Нийт хөрөнгө	2,235,621.5	2,175,465.0	-60,156.5
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,235,621.5	2,175,465.0	-60,156.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,235,621.5	2,175,465.0	-60,156.5

Авлага дансны үлдэгдэл 31,554.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43,305.8 мянган төгрөг болж 13,463.6 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал бурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,132,159.2 мянган төгрөг болж 15,138.8 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө акталсан болон үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,175,465.0 мянган төгрөг болж 60,156.5 мянган төгрөгөөр буурсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 130,407.3 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 12,091.5 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,059,396.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,059,396.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26,922.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,086,318.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,086,318.9 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 899,400.8 мянга, орон нутгийн төсвөөс 186,918.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 899,400.8 мянга, орон нутгийн төсвөөс 186,918.1 мянган төгрөг, нийт 1,086,318.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,076,404.2 мянган төгрөгийг зарцуулж 9,914.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,076,404.1 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь зарлагыг 9,914.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 6,008.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,564.2 мянга, нийт 8,572.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 5,998.0 мянган төгрөгийг зарцуулж 2,274.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Өлгий сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 135, хугацаа хоцроож 14 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр